

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ

Д/д	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт	Нэмэлт оруулах хуулийн төслийн санал /зүйл, хэсэг, заалтаар /	Өөрчлөн найруулах хуулийн төслийн санал/зүйл, хэсэг, заалтаар /	Тайлбар
1	<p>17.2. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргана.</p> <p>17.3. Хувийн хэвшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг байгуулахтай холбоотой харилцааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.</p>		<p>“17.3.Хувийн хэвшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг болон энэ хуулийн 17.2-д зааснаас бусад эрүүл мэндийн байгууллагыг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгахтай холбоотой харилцааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна”</p>	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрлөөр эрүүл мэндийн байгууллагуудыг байгуулдаг бөгөөд нийт 13 төрөл байхаар заасан. Гэтэл хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-д “төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг байгуулах, өөрчлөх, татан буулгах шийдвэрийг Засгийн газар гаргах”, мөн зүйлийн 17.3-д “хувийн хэвшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг”-ийг байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулахаар заасан байна.Үүнээс харахад эрүүл мэндийн бусад байгууллагыг байгуулах асуудал зохицуулалтгүй үлдсэн мэт харагдаж байна. Өнөөгийн байдлаар Дүүргийн эрүүл мэндийн төвүүдийг Засгийн газрын тогтоолоор байгуулсан. Иймд энэ заалтад “бусад эрүүл мэндийн байгууллагыг “ гэсэн нэмэлт оруулж, “ эмнэлгийг байгуулах” гэсний дараа нэмж “ өөрчлөн зохион байгуулах, татан буулгах” асуудлыг ч нэмэх нь зүйтэй байна.</p>
2	19 дүгээр зүйл.Эрүүл мэндийн чиглэлээр	Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх		Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр

	үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох			үйлчилж эхэлсэн. Энэ хуулиар “ тусгай зөвшөөрөл” олгох нийтлэг зохицуулалт болон эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаа болон зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13-д заасан. Иймд эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж шинэчлэх
3	11.1.6. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлөх;		11.1.6. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргатай зөвшилцөн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилох, чөлөөлөх;	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах , томилсон албан тушаалтны өмнө ажлаа хариуцах , тайлагнах зарчмыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой
4	21 дүгээр зүйл. Эрүүл мэндийн байгууллагын дүрэм 21.1. Эрүүл мэндийн байгууллага дүрэмтэй байна. 21.2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын	Энэ зүйлд “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга харьяа эрүүл мэндийн байгууллагын дүрмийг батална” гэсэн хэсэг нэмэх		Тухайн зүйлийн нэр нь “Эрүүл мэндийн байгууллагын дүрэм” гэсэн байх тул үүнд төрийн болон орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн бүх байгууллага хамаарна. Гэтэл тухайн заалтад зөвхөн төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дүрмийг батлах зохицуулалтыг тусгасан байна. Иймд орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дүрмийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга батлахаар мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн газрын

	<p>дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>21.3. Эрүүл мэндийн байгууллагын дүрэмд дараах зүйлийг тусгана:</p> <p>21.3.1. байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг;</p> <p>21.3.2. удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ;</p> <p>21.3.3. санхүүжилтийн эх үүсвэр;</p> <p>21.3.4. хөрөнгийн зарцуулалт.</p>			<p>дүрмийг хянах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд яам болон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар оролцох эсэхийг тодорхой болгох.</p> <p>Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлтэй төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн дүрмийг төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэж батлах уу гэсэн асуудлыг төслийн явцын хэлэлцүүлгээр сайтар хэлэлцэж оновчтой хувилбарыг хуулийн төсөлд тусгах.</p>
--	--	--	--	---

ДАГАЛДАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ӨӨРЧЛӨХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АСУУДАЛД ТУСГУУЛАХ САНАЛ

<p>15.1.6. нийгмийн эрүүл мэндийн төв;</p> <p>16.9. Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл</p>	<p>Хэвээр</p>	<p>Хэвээр</p>	<p>Эрүүл мэндийн тухай хуулийн гол үзэл баримтлал нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс өмнө уг хуулийн Зарчим гэсэн 4 дүгээр зүйлийн 4.2.2-д “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох “-оор заасныг хэрэгжүүлж дүүрэгт “Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах” байсан боловч өнөөгийн байдлаар Засгийн газрын тогтоолоор байгуулсан “ Дүүргийн эрүүл мэндийн төв”-үүдийг байгуулсан нь хуульд байхгүй эрүүл</p>
--	---------------	---------------	---

мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд			мэндийнг байгууллагын бүтэц байгааг засч “ Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулах
--	--	--	--